



# 8-р сарын тайлан

## мэдээ

**Хүүхэд бүхэн инээнэ**
**Ид шидийг бүтээнэ ...**





**2021.08.31**

# Ид шидийн орон ХХХТ-н ТООН ҮЗҮҮЛЭЛТ
# ТҮР ХАМГААЛАХ БАЙРАНД



**НИЙТ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ**

**12**

**ХҮЛЭЭН АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД**

**+3**

## Хүйс

Эмэгтэй **9**

Эрэгтэй **3**

## Нас

2-5 нас **1**

6-10 нас **3**

11-13 нас **4**

**Тайлбар:**

Ид шидийн орон" ХХХТ-н түр хамгаалах байранд 2021 оны 8 сард шинээр 3 үйлчлүүлэгч хүлээн авч, 6 үйлчлүүлэгчийг ар гэрт нь эргэн нэгтгэсэн. Өнөөдрийн байдлаар 12 үйлчлүүлэгч хамгаалах байрны цогц үйлчилгээг авч байна. Үүний 9 эмэгтэй, 3 эрэгтэй. 2-5 насны 1, 6-10 насны 3, 11-14 насны 4, 14-18 насны 4 үйлчлүүлэгч үйлчилгээ авч байна.

# Энэ сарын нийгэмшүүлэх үйл ажиллагаа

## Түр хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгчдийг хүүхдийн парк-д тоглуулсан

**Үйлчлүүлэгчид маань нийгэмшүүлэх үйлчилгээний хүрээнд Үндэсний соёл амралтын хүрээлэнд нэг өдрийг хөгжилтэйгөөр өнгөрүүлэв. Хамаг стресс тайлагдлаа, 5 тоглоом дээр суусан ч 50 тоглоомонд суусан юм шиг сайхан байна л гэнэ. 7 настай нэгэн үйлчлүүлэгч долоо хоног бүрийн пүрэв гаригт парк-д тоголдог баймаар байна гэх санал гаргав. Их л сайхан байсан бололтой.**









# Чадавхжуулах үйлчилгээ

Чадавхжуулах үйлчилгээний хүрээнд Ид шидийн орон 2 төвд ТХБ-ны үйлчлүүлэгчид

- Уран зургийн дугуйлан
- Иогын хичээл болон номын сангаар үйлчлүүлж байна





# Хөгжлийн үйлчилгээ

**Хамгаалах байрны үйлчилүүлэгчид маань Ид шидийн орон улиастай салбарт хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж эхэллээ.**

**Линдагийн зургийн ангид долоо хоног бүрийн даваа, лхагва гаригуудад очиж сургалтанд хамрагдахаар болсон бөгөөд сэтгэл ханамж өндөр байгаа.**

**Цогоо ах 11:30-с ирж авч байгаа ч үйлчлүүлэгчид маань өглөө 8 цагаас эхлээд явахдаа бэлддэг. Орчин солигдоод сайхан байгаа бололтой. Удахгүй илүү олон сургалтууд явагдаж эхлэхээр үйлчлүүлэгчдээ хамруулах бодолтой байна.**





# Сайн дурынхныхаа ачаар

**Цэцэрлэгийн ангид хамгаалах байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор нэмж угсарсан орнуудын угсраag тайлж, хураав.**

Сайн дурынхныхаа ачаар өдрийн дотор дуусгасан.
СДА-нуудаа л хайрладаг юм шүү.







# Magic store

**Үйлчлүүлэгчдэд санхүүгийн боловсрол олгох зорилготой түр хамгаалах байрны дэлгүүрийн тохижилтыг сайжруулав.**






# Хүндэтгэл

Бидний хайрт Гүлсара эгчийнхээ хөшөөнд хамт олон нь хүндэтгэл үзүүллээ.

Бид үйл хэргийг нь үргэлжлүүлсээр нэгэнт 4 жилийн ард гарсан байна.







# Ерөнхий мэдээлэл

- Ид шидийн орон ХХХТ ТХБ-нд хөндлөнгийн мониторинг хийгдэж байна.
- Үйлчлүүлэгчидтэй холбоо асуудлаар дотоод кейс хурал хийж, харьяа дүүргийн хариуцсан мэргэжилтнүүдтэй тогтмол харилцаа холбоотой ажиллаж байна.
- Үйлчлүүлэгчид дэмжих бүлгийн сургалтанд тогтмол хамрагдаж байгаа
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй түр хамгаалах байрнуудтай холбогдож, туршлага солилцох замаар ажилтнуудын аялал хийхээр зэхэж байна. Бидэнд бусдаасаа суралцах, үйлчилгээгээ сайжруулах гэх мэт олон боломжийг тус аяллаас олж авч болох юм.
- 7 үйлчлүүлэгчийн гэр бүлийн уулзалт зохион байгуулагдав



“

Бага ангийн сурагчдаар цаасан нугалаа бие даан хийлгүүлэхэд өөрсдийн хийж чадахгүй байсан нэгэн амьтны нугалааг хамтран хийцгээснээ

“Багшаа хамтын хүчээр бүхнийг чадна гэдэг их үнэн үг юмаа. Бид хамтдаа хийж чадлаа”
хэмээн ярьцгаав.

”



“

Бага ангийн сурагчдад сургалт орох үеэр ийм нэгэн яриа болов.

# Багшаа хүн яаж үүссэн юм бэ?

- Багшаа тэнгэрийн бурхан шавраар хүн хийгээд тэр нь амилсан тэ.
- Үгүй ээ. Хүн байцааны голноос үүссэн тэ багшаа.
- Байцааны голноос оо? Тэгвэл манжин аав нь, төмс ээж нь юм уу? Ямар сонин юм бэ?
- Тийн. Лууван хүүхэд нь.
- Багшаа энэ үнэн юм уу? Гэх мэтчилэн хэсэг мэтгэлцээн болж эцэст нь зөв хариултаа олцгоов.

”



# Санхүүгийн тайлан

ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ
Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал
Цэцэрлэгийн хангамжийн зардал
Сургалт, судалгаа, хөгжүүлэлтийн хэрэглэгдэхүүний зардал

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ
Хамгаалах байрны хүүхдийн хоолны зардал
Хамгаалах байрны хүүхдийн хувцас зардал
Хамгаалах байрны хүүхдийн ахуйн хэрэглэлийн зардал
Сэтгэл заслын үйлчилгээний зардал
Хүүхэд хамгааллын нийгэмшүүлэх үйлчилгээний зардал
Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрүүл мэнд эм хангамж зардал
Хүүхэд хамгааллын үйлчилгээний хангамж зардал/ ус замах анги цэвэрг
Бичиг хэргийн зардал
Томилолтын зардал
Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал
Мэргэжилтнүүдийн цалингийн зардал

АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ
Цахилгаан
Бохир ус
Цэвэр ус
Хог тээвэр
Интернет
Утас ид шидийн орон
Утас хамгаалах байр

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ
Ажилчдын хоолны зардал
Маркетингийн зардал
Ногоон байгууламжийн арчилгааны зардал
Цэвэрлэгээ, ариутгалын зардал
Барилгын засварын зардал
Тоног төхөөрөмжийн засварын зардал
Шатахууны зардал
Тээврийн зардал
Шатахууны зардал ид шидийг орон нэг
Тээврийн зардал ид шидийн орон нэг
Томилолтын зардал ид шидийн орон нэг
Бичиг хэргийн зардал ид шидийн орон нэг
Сургалтын зардал
Uniform, үнэмлэх гм
Татварын зардал Үл хөдлөх, газар
Даатгалын зардал
Ажилчдын цалингийн зардал

НЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ
Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал
Бусад зардал \нотариат, орчуулга, карго\

